



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 07 сарын 24 өдөр

Дугаар А/507

Булган сум

“Булган хангай” шагай харвааны баг,
тамирчдын бэлтгэлд дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Биеийн тамир, спортын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.9 дэх заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6 дахь заалт, аймгийн Засаг даргын 2025 оны “Засаг даргын нөөц хөрөнгөөс тусламж, дэмжлэг олгоход баримтлах журам” батлах тухай А/377 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үндэсний их баяр наадамд аймаг, орон нутгаа төлөөлөн оролцсон “Булган хангай” шагай харвааны баг, тамирчдын бэлтгэлийн зардал 3,000,000 (гурван сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дээрх зардлыг аймгийн Засаг даргын нөөцийн хөрөнгөөс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Наранбаяр)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР